

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Ярилцлага өгөгчийн нэр	Шаравын Марсар	Дугаар	L125
Оршин суугаа аймаг	Сүхбаатар	Оршин суугаа сум	Халзан
Төрсөн газар	Халзан	Төрсөн он	1934
Ажил мэргэжил	Өндөр настан		
Лам байсан эсэх, Шавилан сууж байсан сүм хийд	Халзан Хатавчийн хийд	Сүм хийдийн дугаар	СБХЛ 037
Одоогийн сүм хийд		Сүм хийдийн дугаар	
Ярилцлага авсан он сар өдөр	2007 оны 9-р сарын 4	Ярилцлага авсан хүн	Ж.Одгарьд



Сүхбаатар аймгийн Халзан сумын Хатавчийн хийд

- Хатавчийн хийдийн тухай өөрийн мэдэх зүйлээ ярьж өгнө үү?

Сумын үрд зүүн доор суварга байгаагийн тэнд хийдийн туурь. Зүүний дуган, барууны дуган гээд том хийд байсан юм аа. Сүүлдээ хүн эмнэлэг, хоршоо, дэлгүүр, ноос авдаг газар болчихсон байж байсан. Тэгээд сүүлдээ зөөгөөд энэ дээр гаргаж ирсэн. Захиргаа, худалдаа бэлтгэлийн анги энэ тэр бариад. Шинээр Хатавчийн хийдээ сэргээгээд яахав.

-Хатавчийн хийд хуучин хэдэн дугантай, хэр олон ламтай хийд байсан бэ? Хатавчийн хийд нь 500 ламтай зүүний дуган, барууны дуган гэдэгтэй тийм л хийд байсан.

-Өөр ямар ямар дацангууд байсан бэ?

Олон дацан байсан.

-Хэдэн дацан байсан бэ?

Мэдэхгүй.

-Байгуулагдсан он цагийн хувьд?

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Тэр одоо хэзээ юм бол? Хоёр номтой банди тэгж байсан. Тэгсэн манайхны Билэгт лам гэл үү нэг лам нь цуг явж байгаад Халзан Хатавчийн хийдийг би энэ аманд байгуулна гэж тэгтэл нөгөөдөх нь чамд нэг хадтай хавцал олдсон юм надад нэг хадтай довцог олох байлгүй гээд гүйгээд явсан юм гэнэ. Тэгээд Бөөрийн хийдийг байгуулсан юм гэнэ лээ. Хоёр том хийд үүссэн. Энэ нь 500 гаруй ламтай, нөгөөдөх нь 600-аад ламтай байсан гэсэн. Дээрээсээ зарлигтай байнгын хийд юм гэнэ лээ -Бөөрийн хийд эндээс хэр хол зайтай вэ?

Бөөрийн хийд эндээс 100 км, Асгатаас 50 орчим км урагшаа явна.

Асгатаас Бөөрийн хийдийг хаагаад сүүлд нь Авдарын голын хийд гэж байгуулсан юм болов уу. Тийм юм шиг л яриад байдаг.

-Бөөрийн хийд тийшээ шилжсэн юм үү?

Бөөрийн хийд тэр рүү шилжсэн юм гэсэн. Бөөрийн хийдийн туурь гэж одоо Их –Уул, Дарьгангын замд байгаа.

-Таны сонсож дуулсан эрдэмтэй лам нарын тухай яриа, домог хүүч юу байна?

Манайхны Билэгт лам гэдэг сайн лам байсан юм гэнэлээ.

-Хатавчийн хийдийн тэргүүн нь үү?

Тийм. Бадар бариад их л явж байсан хүн гэсэн. Бадарчин явсан газар балагтай гэж нь айл жасаагаа тахиж байсантай таарч гэнэ. Тэр айл бадарчин ирлээ гээд оруулахгүй хотныхоо нэг хөгшнийд оруулж тэр айлд цай ууж мод толгой гаргаад тамхи татаад аяганы ширээн дээр нь гансаа тогшоод цогоо хаяад байж гэнэ. үнс нь шовойгоод байсан. Тэгээд яахав явж гэнэ. Гараад явахаар нь үнсийг нь цэвэрлэх гэсэн салдаггүй гэнэ. 7 сар болсон гэсэн. Тэр айл бадарчинг буцаан авчирч жасаагаа тахиулж байсан гэдэг.

-Билэгт лам дараа нь тодорч байсан уу?

Билэгт лам 7 хувирсан гэсэн.